



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОО-2021/24/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын

менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.com

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
Аудитын зөвлөмж.....	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.18 № 77
танай _____-ны № _____-т

ГУРВАНЗАГАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.АЗЗАЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванзагал сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гурванзагал сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гурванзагал сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

011020118

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	117,979.62
35	БАРАА МАТЕРИАЛ	-	117,979.62
354	Хангамжийн материал	-	117,979.62
35410	Бичиг хэргийн материал	-	39,000.00
35440	Түлц, шатах тослох материал	-	78,979.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,000.08	26,000.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,000.08	26,000.12
392	Биет хөрөнгө	39,000.08	26,000.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,263,000.00	3,263,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,263,000.00)	(3,263,000.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	654,835.00	654,835.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(615,834.92)	(628,834.88)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	39,000.08	143,979.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	39,000.08	143,979.74
51	Засгийн газрын хувь оролцоо	39,000.08	143,979.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	799,000.00	799,000.00
51101	Өмч: - төрийн	799,000.00	799,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(783,619.29)	(678,639.63)
51210	Өмнөх үеийн үр дүн	(783,619.29)	(783,619.29)
51220	Тайланг үеийн үр дүн	-	104,979.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,619.37	23,619.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	39,000.08	143,979.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	49,196,600.00	217,542,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49,196,600.00	217,542,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	162,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	161,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,196,600.00	55,542,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	48,196,600.00	55,542,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	49,209,600.00	217,437,020.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,209,600.00	217,437,020.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,098,539.43	213,407,976.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,361,401.71	43,195,620.68
210101	Үндсэн цалин	27,234,862.71	32,419,213.68
210102	Нэмэгдэл	2,997,439.00	3,319,947.00
210104	Урамшуулал	6,129,100.00	7,456,460.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,779,037.71	4,467,395.21
210201	Тэтгэврийн даатгал	2,569,745.65	3,037,828.74
210202	Тэтгэмжийн даатгал	302,323.02	357,391.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	241,858.41	285,913.29
210204	Ажилгүйдлийн даатгал	60,464.60	71,478.32
210205	Эрүүл мэндийн даатгал	604,646.03	714,783.23
2104	Хангамж, бараа материалын зардал	4,617,500.00	2,331,960.38
210401	Бичиг хэрэг	1,596,130.00	561,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,221,870.00	1,295,960.38
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	370,000.00	475,000.00
210404	Ном, хэвлэл	429,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	840,000.00	-
210604	Урсгал засвар	840,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,542,100.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	1,542,100.00	250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	674,500.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	374,500.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,284,000.01	163,012,999.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,271,000.00	163,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,000.01	12,999.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	111,060.57	4,029,044.11
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	111,060.57	4,029,044.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,060.57	4,029,044.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(13,000.00)	104,979.66
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(13,000.00)	104,979.66



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	49,196,600.00	217,542,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49,196,600.00	217,542,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	162,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	161,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,196,600.00	55,542,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,196,600.00	55,542,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	49,196,600.00	217,542,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,196,600.00	217,542,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,085,539.43	213,512,955.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,295,339.43	43,195,620.07
210101	Үндсэн цалин	30,166,239.43	22,822,637.33
210102	Нэмэгдэл	-	12,916,522.74
210104	Урамшуулал	6,129,100.00	7,456,460.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,845,100.00	4,467,395.82
210201	Тэтгэврийн даатгал	2,646,400.00	3,017,618.00
210202	Тэтгэмжийн даатгал	303,700.00	362,443.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	239,000.00	290,055.00
210204	Ажилгүйдлийн даатгал	59,600.00	72,489.00
210205	Эрүүл мэндийн даатгал	596,400.00	724,790.82
2104	Хангамж, бараа материалын зардал	4,617,500.00	2,449,940.00
210401	Бичиг хэрэг	1,450,000.00	600,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,368,000.00	1,374,940.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	370,000.00	475,000.00
210404	Ном, хэвлэл	429,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	840,000.00	-
210604	Урсгал засвар	840,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,542,100.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	1,542,100.00	250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	674,500.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	374,500.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,271,000.00	163,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,271,000.00	163,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	111,060.57	4,029,044.11
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	111,060.57	4,029,044.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,060.57	4,029,044.11
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	799,000.00	23,619.37	-783,619.29	39,000.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	799,000.00	23,619.37	-783,619.29	39,000.08
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайланг үеийн үр дүн				0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	799,000.00	23,619.37	-783,619.29	39,000.08
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	799,000.00	23,619.37	-783,619.29	39,000.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	799,000.00	23,619.37	-783,619.29	39,000.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	104,979.66	104,979.66
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	799,000.00	23,619.37	-678,639.63	143,979.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,056,000.00	51,512,955.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,056,000.00	51,512,955.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,756,000.00	51,512,955.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,449,500.00	43,195,620.07
210101	Үндсэн цалин	24,305,000.00	22,822,637.33
210102	Нэмэгдэл	13,612,700.00	12,916,522.74
210104	Урамшуулал	7,531,800.00	7,456,460.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,135,700.00	4,467,395.82
210201	Тэтгэврийн даатгал	4,317,700.00	3,017,618.00
210202	Тэтгэмжийн даатгал	454,500.00	362,443.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	363,600.00	290,055.00
210204	Ажилгүйдлийн даатгал	90,900.00	72,489.00
210205	Эрүүл мэндийн даатгал	909,000.00	724,790.82
2104	Хангамж, бараа материалын зардал	2,770,800.00	2,449,940.00
210401	Бичиг хэрэг	650,000.00	600,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,606,800.00	1,374,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,000.00	475,000.00
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,000.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56,056,000.00	55,542,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,056,000.00	55,542,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	56,056,000.00	55,542,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	162,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	162,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	162,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	162,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	162,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	162,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	162,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг нарийн бичгийн дарга Б.Аззаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 10–ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн дагуу нутгийн өөрөө удирдах ёсны удирдлагыг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй болно.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан



төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 51,480.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 1,029.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 64,432.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 1,308.6 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,705.3 мянган төгрөгөөр буюу 45.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцооны дансанд гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	1,933.0	3,329.0	1,396.0
Үндсэн хөрөнгө	6,246.2	8,555.5	2,309.3
Нийт хөрөнгө	8,179.2	11,884.5	3,705.3
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,179.2	11,884.5	3,705.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,179.2	11,884.5	3,705.3

Бараа материалын дансны үлдэгдэл 3,329.0 мянган төгрөг болж 1,396.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тусгай зориулалтын материал 65.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 258.0 мянган төгрөг, аж ахуйн материал 1,073.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 8,555.5 мянган төгрөг болж 2,309.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан тоног төхөөрөмжөөс шалтгаалсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь тайлант оны худалдан авалтаар нийт 4,092.2 мянган төгрөгийн

тоног төхөөрөмж /notebook, дуу хураагч, олон үйлдэлт принтер/-өөр нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 1,782.9 мянган төгрөгөөр болсноос шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нь 11,884.5 мянган төгрөг болж 3,705.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 213,273.6 мянган төгрөгөөр буюу 415.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь тайлант онд хэлмэгдсэн иргэдийн гэр бүл, үр хүүхдэд олгосон нөхөн олговор 200,000.0 мянган төгрөгийг олгосонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 213,273.6 мянган төгрөгөөр буюу 440.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан “төрөөс иргэдэд олгох тэтгэмж”-ийн зардал байна. Энэ нь сумын ИТХ-ын дансаар дамжуулан иргэдэд “төрөөс иргэдэд олгох тэтгэмж”-ийн зардлын ангиллын дагуу олгосонтой холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 83,900.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 83,900.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. 19,467.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 64,432.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан санхүүжүүлэхээр 64,432.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон төсвөөс 64,432.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 63,578.4 мянган төгрөгийг зарцуулж 854.3 мянган төгрөгийг орон төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 63,578.4 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 854.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас /гэмт хэргээс урьдчилан сэргийлэх/ 1,000.0 мянган төгрөг, хэлмэгдсэн иргэдийн ар гэрт 200,000.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Тус санхүүжилтээс “бараа үйлчилгээний бусад зардал”-д 1,000.0 мянган төгрөг, “төрөөс иргэдэд олгох тэтгэмж” 200,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 114 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж, 37 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 зарлагын 200.0 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 200,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 200,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай зөрчил гараагүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 200.0 сая төгрөгийн залруулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

1. Тайлант онд нийт 200.0 сая төгрөгийн 5 зардлын гүйлгээг шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/24/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд нийт 200.0 сая төгрөгийн 5 зардлын гүйлгээг шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээлээгүй байна.	200,000.0	Албан шаардлага	Дарга	Б.Азжая
ДҮН		200,000.0			